



“Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийн I-р шат болох зуны дугуйн аялал, амралт зугаалгын хөтөлбөрийн тайлан

Төслийн үе шат:

- ✓ “Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийн I-р шат болох зуны дугуйн аялал, амралт зугаалгын хөтөлбөр /VIII/30 - X/04 өдөр/
- ✓ “Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийн II-р шат болох өвлийн үйл ажиллагаа, цас мөсний хотхон /XII/01 – III/21 өдөр/

Төсөл санаачлагч: “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ



Төслийн дэмжигч байгууллага: НЗДТГ, Найрсаг Улаанбаатар төсөл, НБТСГ



Хамтран зохион байгуулагч холбоо, клуб, дэлгүүрүүд:



МОНГОЛЫН
МЭРГЭЖЛИЙН
ЭКСТРЕМ
ХОЛБОО ТББ



“Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийн I-р шат болох зуны дугуйн аялал, амралт зугаалгын хөтөлбөрийн тайлан

2014 оны 09 сарын 01 өдөр

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл даргын захирамжаар нийслэлийн иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-аас “Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийг боловсруулан ажиллав. “Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийн логог зохиох, вэб сайтад зар сурталчилгааны хуудас, баннер байрлуулах, 25 секундын телевизорын реклам хийлгэж цацах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

“Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийн I-р шат болох зуны дугуйн аялал, амралт зугаалгын хөтөлбөрийн нээлтийн ажиллагаа 2014 оны 08 сарын 30 –ны Бямба гаригт Монгол наадам цогцолбор буюу Хүйн долоон худагт амжилттай зохион байгуулагдсан.

Тус нээлтэд Нийслэлийн засаг даргын орлогч Ц.Энхцэнгэл, МДХ-ны хүндэт ерөнхийлөгч Л.Хангай, “МНЦ” ОНӨТҮГ-ийн дарга П.Цогтбаатар нар оролцон үг хэлж мөн залуу хамтлаг дуучид ирж ая дууны мэнд дэвшүүлсэн юм. Энэ өдөр МДХ-ны нэрэмжит Уулын дугуйн улирлын хаалтын тэмцээн, Төслийн нэрэмжит сонирхогчдын уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээн насанд хүрэгчдийн ангилалд эрэгтэй, эмэгтэй 2 төрлөөр 3 насанд, МДТХ-ны ээлжит аварга шалгаруулах тэмцээн 5 насны ангилалд тус тус зохиогдож аваргаа шалгарууллаа. Арга хэмжээний үеэр нийт унадаг дугуйн түрээсийн 7 цэг ажиллаж зорин ирсэн хүүхэд, залуусыг дугуйн түрээс, засварын үйлчилгээгээр хангаж байсан юм.

Энэхүү төслийг НЗДТГ, НБСГ, МДХ, МЗХ, Унадаг дугуйтай Улаанбаатар төсөл, Монголын экстрем спортын холбоо, Трек унадаг дугуйн худалдаа, түрээсийн байгууллага зэрэг улс, хувийн хэвшлийн нийт 13 байгууллага, клуб, холбоод дэмжин хамтран зохион байгуулсан.

“Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийн дугуйн аялал, амралт зугаалгын нээлтийн арга хэмжээний үеэр 400 гаруй дугуйчид, 300 гаруй сонирхогч хүүхэд залуус цугларсан бөгөөд сонирхогчдын уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээнд гараанаас 70 сонирхогч зэрэг гарсан нь Монголын дугуйн түүхэнд байгаагүй олон тамирчин цугларч, гараанаас гарсан тэмдэглүүштэй арга хэмжээ

боллоо хэмээн МДХ-оос мэдэгдсэн байна. Мөн дугуйн мэргэжлийн тамирчид болон дугуй сонирхогч залуус зориулалтын зам талбайд авто машины хөдөлгөөнөөс зайдуу унадаг дугуйгаар аялж амрах боломж олгон эрүүл, эко санаачилга гаргасан Монгол Наадам Цогцолборт талархаж байгаагаа хэлж байсан юм.

НЭЭЛТИЙН АЖИЛЛАГААНЫ ЗУРАГ



Нээлтийн тууз хайчлах ёслолд Нийслэлийн засаг даргын орлогч Ц.Энхцэнгэл, Нийслэлийн засаг даргын орлогч О.Очирбат, “МНЦ” ОНӨТҮГ-ийн дарга П.Цогтбаатар, МДХ-ны хүндэт ерөнхийлөгч Л.Хангай нар оролцлоо.



Нээлтийн ажиллагааны үед Шанхай спеско группын Монголын талыг хариуцсан захирал Мартин Зинг оролцож Монгол наадам цогцолборт ОНӨТҮГ-т 100 ширхэг

Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын 2014 оны тайлан, гүйцэтгэл унадаг дугуй хандивлахаар болов. Мөн нээлтийн ажиллагаанд оролцохоор Багануур дүүргийн дугуйн спортын 16 тамирчин унадаг дугуйтайгаа ирж оролцов.



Арга хэмжээний үеэр Монголын дугуйт тэшүүрийн холбооны нэрэмжит улирлын аварга шалгаруулах тэмцээн боллоо. Уг тэмцээнд 80 гаруй тамирчин оролцсон байна.



“Эрүүл иргэн- Эко хөгжил” төслийн дугуйн аялал, амралт зугаалгын нээлтийн арга хэмжээний үеэр 400 гаруй дугуйчид, 300 гаруй сонирхогч хүүхэд залуус цугларав.

Сонирхогчдын уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээнд гараанаас 70 сонирхогч зэрэг гарсан нь Монголын дугуйн түүхэнд байгаагүй олон тамирчин цугларч, гараанаас гарсан тэмдэглүүштэй арга хэмжээ боллоо хэмээн МДХ-оос мэдэгдсэн байна.



ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2014 оны 10 дугаар сарын 06 өдөр

Хүйн долоон худаг Монгол наадам цогцолборт “Эрүүл иргэн- Эко хөгжил” дугуйн аялал, амралт зугаалгын хөтөлбөрийн зуны арга хэмжээний хаалтын ажиллагаа 10 сарын 4-ны Бямба гарагт боллоо. Тус хаалтын ажиллагааны үеэр “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ийн нэрэмжит сонирхогчдын уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээн 3 насны ангилалд, мэргэжлийн уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээн эрэгтэй, эмэгтэй төрлөөр зохион байгуулагдлаа.



Уулын дугуйн сонирхогч болон мэргэжлийн тамирчдын дунд зохион байгуулагдсан аварга шалгаруулах тэмцээнд давхардсан тоогоор нийт 110 гаруй тамирчин хурд, хүч, авхаалж самбаагаа сорин оролцлоо.





Уулын дугуйн сонирхогчдын эрэгтэй, эмэгтэй төрөл мөн мэргэжлийн эрэгтэй, эмэгтэй уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээн болов.

Тэмцээнд Аттила дугуйн клуб, Трек дугуйн худалдаа, түрээсийн дэлгүүр, Байсикел пикс шоп дугуйн худалдаа, түрээсийн дэлгүүр оролцож дугуйн худалдаа үйлчилгээ, түрээсийн цэг ажиллууллаа. Хаалтын ажиллагаанд нийт 400 орчим тамирчин, сонирхогч хүүхэд, залуус оролцов.

Мөн тэмцээний үеэр Монголын экстрем спортын холбооны тамирчид олон сонирхолтой үзүүлбэрүүдээрээ үзэгчдийг баясгав.



Хаалтын ажиллагааны үеэр Монголын цанын холбооны ерөнхийлөгч Р.Раш “Эрүүл иргэн – Эко хөгжил” төсөлд хамтран оролцож байгаа мөн цаашид ямар чиглэлээр хамтран ажиллах талаар үг хэлэв.

Хаалтын ажиллагаанд Монголын цанын холбоо оролцож улирлын аварга шалгаруулах тэмцээнээ хийв.



Дугуйн аялал, амралт зугаалгын үеэр н.Мөнхчулуун Амь дүйсэн аяллын хөтөч номын худалдаагаа гаргаж 2014 оны 11 дүгээр сарын 01-нд унадаг дугуйгаар Гимлай нуруу руу аялах аяллын танилцуулах ажлаа хийлээ.



Нийтийн тээвэр



Төслийн үеэр нийтийн тээврийг үнэ төлбөргүйгээр явуулсан нь дугуй сонирхогч хүүхэд залуусын зүгээс ихээхэн сайшаагдсан явдал боллоо.

Жич: Төсөлтэй холбоотой баримтуудыг хавсаргав.

Тайлан бэлтгэсэн:

“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ
Маркетингийн хэлтэс